



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

“Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг
тэмдэглэн өнгөрүүлэх, удирдамж,
төсвийг батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 21 дүгээр зүйл ЦССҮТ-ийн Захирлын 2025 оны А/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр тэмдэглэх удирдамжийг 1 дүгээр, зарцуулах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамж, төсвийн дагуу “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулж, тайланг ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газарт хүргүүлэхийг Захиргаа, маркетингийн албаны дарга, ажлын хэсгийн ахлагч (Ч.Батболд), Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга, ажлын хэсгийн гишүүн (Л.Энхчимэг) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын 2 дугаар хавсралтад заасан зардлыг хөтөлбөр төслийн зардлаас шийдвэрлэхийг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч (Х.Одгэрэл)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод аудитор (Т.Алимаа)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

ЦССҮТ-ийн Захирлын 2025 оны
05 дугаар сарын 17 ны өдрийн
1132 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

1118266548 9128905

“ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ УДИРДАМЖ

Сэдэв: Цусаа өгч, Итгэл түгээе: Хамтдаа амьдрал бэлэглэе!

Үндэслэл:

Жил бүрийн 06 дугаар сарын 14-нд дэлхийн улс орнууд хүний амь аврах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулдаг сайн дурын, авлагагүй цусны донорууддаа талархал илэрхийлэх **Цусны донорын Дэлхийн Өдөр**”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Мөн цус сэлбэлт шаардлагатай байгаа өвчтөнүүдэд чанартай, аюулгүй, хүртээмжтэй цус, цусан бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тогтмол хугацаанд цусаа хандивлах шаардлагатайг олон нийтэд таниулах зорилготой. Үүний зэрэгцээ, энэ өдөр улс орон бүрийн Засгийн газар, Эрүүл мэндийг байгууллагуудыг сайн дурын, авлагагүй доноруудаас цус цуглуулалтыг нэмэгдүүлэх, цус сэлбэх заалттай хүн бүрд чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг хүргэхэд шаардлагатай бүхий л нөөцийг бүрдүүлэхийг уриалан дууддаг билээ.

Жирэмслэлт, төрөлттэй холбоотой цус алдсан эмэгтэйчүүд, мөн хумхаа, тэжээлийн дутагдлын улмаас хүнд хэлбэрийн цус багадалтад өртсөн хүүхдүүдийн амь насыг аврахад цус сэлбэлт нь чухал ач холбогдолтой. Бага орлоготой орнуудад төрөх насны эмэгтэйчүүд болон тав хүртэлх насны хүүхдүүд хамгийн олон цус сэлбэлт хийлгэдэг байна. Цус сэлбэлт нь дэлхий улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны салшгүй чухал хэсэг бөгөөд мэс засал, бусад нарийн төвөгтэй олон ажилбарын үед өвчтөний амь насыг аварч, амьдралын чанарыг сайжруулах хэрэгсэл болдог. Цус сэлбэлт нь ялангуяа насан туршдаа байнга эмчилгээ хийлгэх шаардлагатай хадуур эсийн өвчин, талассеми, гемофили болон дархлал дутмагшлын эмгэгтэй хүмүүсийн хувьд онцгой ач холбогдолтой бөгөөд байгалийн гамшиг, осол гэмтэл, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүмүүсийг эмчлэхэд ч онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Цус сэлбэлт шаардлагатай хүн бүрийг аюулгүй бүтээгдэхүүнээр хангахын тулд улс орон бүр тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг сайн дурын, авлагагүй доноруудын хүрэлцээтэй нөөцийг бүрдүүлсэн байх ёстой. Цусны байнгын хэрэгцээг хангахын тулд олон нийтийн идэвхтэй оролцоотой, хүчирхэг, тогтвортой цусны донорын хөтөлбөртэй байх зайлшгүй шаардлагатай. Гэсэн хэдий ч олон улс орнууд цусны аюулгүй байдал, хүртээмж, нөөц, хангамжийн аль алинд нь томоохон бэрхшээл сорилтуудтай тулгарсаар байна. Маш олон тохиолдолд өвчтөнүүд яаралтай үед шаардлагатай цус сэлбэлтийг цаг хугацаанд нь авч чадахгүй байна. Цус, цусан бүтээгдэхүүний хомсдол нь дэлхий нийтийг хамарсан асуудал болж байгаа ч бага, дунд орлоготой орнуудад илүү хурцаар тавигдаж байна.

Зорилго:

Энэхүү уриа нь донорууд цусаа бэлэглэснээр тусламж хэрэгтэй байгаа олон хүний амьдралыг өөрчилж чадахыг онцолж байна. Цусаа хандивлах энгийн үйлдэл нь олон хүний амийг авардаг бөгөөд үүнд хамтын хичээл зүтгэл, эв нэгдэл хүчтэй нөлөөтэй болохыг харуулахыг зорьсон. Энэ аян нь цусны донорын ачаар амь нас нь аврагдсан хүмүүсийн бодит түүхийг сурталчлах, доноруудын туршлага, сэтгэгдлийг хуваалцах, тогтмол хугацаанд цусаа

бэлэглэдэг байнгын доноруудыг урамшуулах, эрүүл хүмүүс ялангуяа залуучуудыг цусаа бэлэглэн цусны донор болохын ашиг тусыг ухамсарлуулан уриалан дуудах зорилготой.

Аяны хүрээнд Цусны донорын Дэлхийн өдрийн энэ жилийн уриаг тайлбарлан сурталчлах, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн олон талт хэлбэрийг ашиглан цусны донорын тухай нэвтрүүлэг, уулзалт ярилцлага хийх, доноруудад талархал илэрхийлэх, соёл урлагийн арга хэмжээ зэрэг үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

2025 оны арга хэмжээний зорилтууд:

1. Улс орон даяар сайн дурын, авлагагүй цусны донорын үйлсийг сурталчилсан, талархал, хүндэтгэлийн арга хэмжээг өргөн хүрээнд үр дүнтэй зохион байгуулах;
2. Хүндэт донор, тогтмол хугацаанд цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэдэг байнгын доноруудад талархал илэрхийлэх, хамт олон, нийгмийн дунд алдаршуулах;
3. ДЭМБ-ын 2025 оны уриа, сурталчилгааны материал, сайн дурын болон хүмүүнлэгийн байгууллагын төлөөлөгч нарыг оролцуулсан сургалт, сурталчилгааны зурагт хуудас, нугалбарыг бэлтгэн нийтэд түгээх;
4. Донорууд цус, сийвэнгээ бэлэглэх нэн чухал хэрэгцээ, шаардлага болон өвчтөний эрүүл мэнд, амьдралд үзүүлэх эерэг сайн нөлөөллийн талаар олон нийтэд таниулан сурталчлах, мэдлэгийг дээшлүүлэх,
5. Анх удаа цусаа бэлэглэн цусны донорын эгнээнд нэгдэж байгаа шинэ донорууд болон донорууд тогтмол хугацаанд цусаа бэлэглэж байнгын донор болж, цус, цусан бүтээгдэхүүний байнгын, тогтвортой нөөц, хангамжийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулахыг уриалах,
6. Цусны донорын өвчтөний эрүүл мэнд, амьдралын сайн сайхан байдалд үзүүлэх эерэг нөлөөллийг онцолж, цусаа бэлэглэн эв нэгдэл, хүмүүнлэг энэрэнгүй үйлс, хамт олны үнэт зүйлсийг сурталчлах, доноруудыг дэмжиж урамшуулах,
7. Засгийн газар болон хамтран ажиллах түншүүдийн дэмжлэгийг татан, дэлхий даяар аюулгүй цус сэлбэлтийг бүх нийтэд хүртээмжтэй болгохын тулд үндэсний цусны хөтөлбөрт хөрөнгө оруулж, тогтвортой хөгжүүлэхийг дэмжих зэрэг болно

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан уриалгыг дэмжин орон даяар Цусны донорын Дэлхийн өдрийг тэмдэглэн, цусны донорын талаар сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахыг уриалах;
- ЭМЯ, Олон улсын байгууллага, Төрийн болон төрийн бус байгууллага, цусны донорууд, нийт ард иргэдийн төлөөлөл, сайн дурын ажилтан, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг оролцуулан “Цусны донорын Дэлхий өдөр”-ийн хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах;
- Цусны донорын Дэлхийн өдрийн Хүндэтгэлийн арга хэмжээний үеэр шинээр болзол хангасан Хүндэт донор, цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ тогтмол хугацаанд өгч болзол хангасан байнгын донорын төлөөлөл, тухайн жилд хамгийн олон удаа цус өгсөн донор, донорын үйлс, хүмүүнлэгийн арга хэмжээг талархан тууштай дэмждэг байгууллага, хамт олны төлөөлөлд талархал илэрхийлэн, алдаршуулах;
- Цусны доноруудыг алдаршуулах, арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулах, сурталчлах;

- Цусны донорын талаарх мэдээлэл бүхий санамж, зөвлөмж, зурагт хуудас бусад материалыг бэлтгэн боловсруулж, хэвлүүлэн сургалт сурталчилгаанд ашиглах;
- Донорын сургалт сурталчилгаанд олны танил хүмүүсийг урьж, олон нийтийг донорын үйлсэд уриалах;
- Цусны донорын Дэлхийн өдрийн уриа, удирдамж, донор алдаршуулалтын мэдээллийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон Цусны салбар төвүүд цахим орчинд байршуулж үндэсний хэмжээнд сурталчлах;
- Цусны донорын сургалт сурталчилгаанд сайн дурын ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх.

Санхүүжүүлэгч байгууллага:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага-20.3 сая
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв-11.6 сая
3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэн

Хэрэгжүүлэгч байгууллага:

1. Эрүүл мэндийн яам
2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв
3. Цусны салбар төв
4. Монголын Улаан загалмай нийгэмлэг
5. Монголын донорын холбоо ТББ

Хугацаа:

2025 оны 06 дугаар сарын 14.

Гарах үр дүн:


- ДЭМБ-ын хэрэгжүүлж буй ЦДДӨ-ийн уриа, удирдамжийн хэрэгжилт хангагдана.
- Цусны донорын талаарх сургалт сурталчилгааны мэдээллийн бааз нэмэгдэнэ.
- Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлага сайжирна.
- Цус цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэхэд тодорхой нөлөө үзүүлнэ.

Боловсруулсан:

Захиргаа, маркетингийн албаны дарга

 БАТБОЛД

ЦССҮТ-ийн Захирлын 2025 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн
А/32 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Уриа: Цусаа өгч, Итгэл түгээе: Хамтдаа амьдрал бэлэглэе!

№	Шагналын нэр	Тоо хэмжээ	Огноо	Зарцуулагдах төсөв	Тайлбар
1. ЦДДӨ-ийн үйл ажиллагааны зардал					
10.	ЦДДӨ-ийн Хүндэтгэлийн арга хэмжээний хөтлөгч	1	2025.06.14	1*1,500,000 =1,500,000	Төсвийн санхүүжилт
11.	Хүндэтгэлийн арга хэмжээний урлагийн мэндчилгээ	4	2025.06.14	4*500,000=2,000,000	
12.	Хүндэт зочид, хүндэт донор, шагнагдсан доноруудад гарын бэлэг, тор бэлтгэх	100	2025.06.14	100* 50,000=5,000,000	
13.	Хүндэт зочид, хүндэт доноруудад цай, кофе, ус	318	2025.06.14	318*10,000=3,180,000	
	ДҮН			11,680,000	

---oOo---